



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/543

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дахь хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.9 дэх заалт, Гадаадын эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах комиссын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 11 дүгээр тэмдэглэл, 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тэмдэглэл, 12 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар тэмдэглэл, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн 5 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж, баталгаажуулан олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Захиргаа, санхүү-үйлчилгээний албаны дарга /Л.Оюунчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн сайдын
 2017 оны 12 сарын 28-ны өдрийн
 АСХЗ дугаар тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сөрм/дугаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Свасти Сингх Singh Swasthi	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	"Медика Монголиа" ХХК-ийн "СОС Медика Монголиа" эмнэлэг	ГЭ00001859	Яаралтай тусламж судлал	Эмчлэх лийн төрөл	1 жил хүчинтэй хугацаа
2.	Сингх Ражендер Пал Singh Rajender Pal	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	"Солонго Хараа" ХХК-ийн эмнэлэг	ГЭ00001860	Нүд судлал /шилгэнцэр, болгрын мэс засал/	Эмчлэх	1 жил
3.	Магсарын Хишигт Нехиге	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	"Өлзий Үрэл" ХХК-ийн "Өлзий Үрэл" эмнэлэг	ГЭ00001861	Уламжлалт анагаах ухаан судлал	Эмчлэх	1 жил
4.	Жон Сү Гён Jung Soo Kyung	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Си Эл Дабльо Эйч" ХХК-ийн "Си Эл Дабльо Эйч" эмнэлэг	ГЭ00001862	Эх барих, эмэгтэйчүүд судлал	Эмчлэх	1 жил
5.	Чун Мун Уг Chung Moon Ok	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Ач тус хоспис" ХХК-ийн "Агаге" хоспис	ГС00000227	Хөнгөвчлөх эмчилгээний сувиллахуй судлал	Сувилгах	1 жил